



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 67

Мөрөн

Чиглэл өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “з” дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

1. “Могойн гол” ХК-ийн техник технологийн шинэчлэл хийх уул уурхайн машин тоног төхөөрөмж /4 ширхэг хөрс тээврийн автомашин, 1 ширхэг өрмийн машин, 1 ширхэг экскаватор/ худалдан авах асуудлыг судалж шийдвэрлүүлэхээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Могойн гол ХК-ийн Орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нарт үүрэг болгосугай.

2. Уул уурхайн машин тоног төхөөрөмж худалдан авахдаа баримтлан ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Худалдан авах техник хэрэгслий төлбөрийг компанийн эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүйгээр шийдвэрлэхийг компанийн захирал /Б.Хашбат/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Гончиг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны
05 дугаар сарын 04-ний өдрийн
67 дугаар тогтоолын хавсралт

**“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ГИШҮҮДЭД ӨГӨХ УДИРДАМЖ**

“Могойн гол” ХК-д хөрөнгө оруулалт хийж уул уурхайн машин тоног төхөөрөмж худалдан авах асуудлыг судлаж ТУЗ, ХЭХ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлэхдээ дараах удирдамжийг хэрэгжүүлж ажиллана.

1. Орон нутгийн өмчлөлийн хувь хэмжээг бууруулахгүй байх.
2. Худалдан авах уул уурхайн машин тоног төхөөрөмж нь Могойн голын уурхайн уул геологийн нөхцөл, Тэсийн сав газрын цаг уурын нөхцөлд тохирсон хүчин чадалтай байхаар техникийн тодорхойлолтыг боловсруулах.
3. Худалдан авах машин тоног төхөөрөмж нь техникийн аюулгүй ажиллагааны хувьд Монгол улсад мөрдөж байгаа стандарт шаардлагыг бүрэн хангасан болохыг нотлох тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн баталгаатай байх
4. Машин тоног төхөөрөмжийг нийлүүлэгчийг сонгох ажиллагааг худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
5. Худалдан авсан хөрөнгийн төлбөрийг компанийн эдийн засгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлд хүндрэл учруулахгүйгээр шийдвэрлэх /төлбөрийг бараа бүтээгдэхүүн, санхүүгийн түрээс гэх мэт санхүүжилтийн боломжит хувилбараар санхүүжүүлэх/ зарчмыг баримтлан ажиллах үүрэг чиглэлийг хүргүүлж байна.

Тогтоолыг хэрэгжүүлж үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг мэдэгдье.